



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 03 сарын 13 өдөр

Дугаар А/158

Булган сум

Эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 66 дугаар зүйлийн 66.1, Ойн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.7 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны XIX хуралдааны XIX/08 дугаар тогтоолын 6 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Ойн сан бүхий газарт ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх зорилгоор хамгаалалтын шороон зурвас байгуулах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулах эрхийг Хутаг-Өндөр сумын Засаг дарга (П.Лхагва-Очир), Сэлэнгэ сумын Засаг дарга (Б.Ууганбаяр)-д тус тус шилжүүлж, зардлын хуваарилалтыг хавсралтаар баталсугай.

2.Дээрх ажилд шаардлагатай 20,000,000 (хорин сая) төгрөгийг Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээний, ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх зорилгоор хамгаалалтын шороон зурвас байгуулах (64 га, Хутаг-Өндөр, Сэлэнгэ сум) төсөл арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг нягтлан бодогч (Б.Бумцэнд)-д зөвшөөрсүгэй.

3.Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, мэргэжлийн болон арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Онцгой байдлын газар (хурандаа Ш.Баасандорж), Байгаль орчин, аялал жуулчлалын газар (А.Гантөмөр)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ



Аймгийн Засаг даргын 2024 оны
03 дугаар сарын 13-ны өдрийн А/18 дугаар
захирамжийн хавсралт

Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх зорилгоор
хамгаалалтын шороон зурвас байгуулах

Д/д	Ажлын нэр төрөл	Батлагдсан төсөвт өртөг (мян.төг)	Эрх шилжүүлсэн сумын Засаг даргын нэр
1	2	3	4
1	Хамгаалалтын шороон зурвас байгуулах (Хутаг-Өндөр сум)	10,000.0	П.Лхагва-Очир
2	Хамгаалалтын шороон зурвас байгуулах (Сэлэнгэ сум)	10,000.0	Б.Ууганбаяр